

ОХУ-ЫН ЭРХҮҮ МУЖИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД

*Ж.Орхон**

Эрхүү муж эдийн засаг-газар зүйн стратегийн чухал байрлалтай, ОХУ-ын Төвийн бүсүүдээс Ази-Номхон далайн сав газрын орнуудтай худалдаа хийх замын огтолцол дээр байрладаг билээ. ОХУ-ын субъектуудын дунд хүн амын орлогоор 23-р байранд ордог нь дундаж үзүүлэлт бөгөөд тус мужийн эдийн засгийн хөгжил улсын дундаж үзүүлэлтээс нилээд доогуур байр эзэлдэг байна. Эрхүү мужийн нутаг дэвсгэр 768 мянган км², байнгын оршин суугч 2,5 сая хүн амтай, мужийн төв болох Эрхүү хотод 582,8 мянган хүн оршин суудаг, аж үйлдвэрийн үндсэн төвүүд нь: Ангарск, Шелехов, Братск, Усть-Илимск зэрэг хотууд юм.

Байгалийн нөөцийн баялгаар ОХУ-д тэргүүлэх байр эзэлдгээс улсын хэмжээнд ой модны нөөцийн 11% бүрдүүлдэг, өөрөөр хэлбэл нийт нутаг дэвсгэрийн 82% -ийг ой мод эзэлдэг. Мөн алт, ховор металл, төмрийн хүдэр, гялтагнуур, тальк, калийн болон чанасан давс, өнгөт чулууны олдвор их хэмжээгээр байдаг. Эдийн засагт түүхий эдийн салбар зонхилдог ба ОХУ-ын мужуудаас хамгийн их түлш эрчим хүчний нөөцтэй, тухайлбал улсын хэмжээнд нүүрсний 7%, мөн тийм хэмжээний газрын тос болон хийн нөөц, усны эрчим хүчний нөөцийн 10%-ийг агуулдаг. Аж үйлдвэрийн үндсэн салбарууд нь төмөрлөгийн (хөнгөн цагаан ба алтны үйлдвэрлэл), ой мод, мод боловсруулах, целлюлоз-цаасны үйлдвэрлэл зэрэг юм. Хөнгөн цагаан ба целлюлоз нь экспортын гол нэр төрлийн бараа болдог байна. Аж үйлдвэрийн 15%-ийг машины үйлдвэрлэл, металл боловсруулалт, тодорхой хэмжээг химийн үйлдвэрлэл тус тус эзэлдэг бол түлш эрчим хүчний салбарт нүүрс голлох байр эзэлдэг байна. Өөрөөр хэлбэл Эрхүү мужийн аж үйлдвэрийн диверсификаци эрчимтэй явагдаж байна гэж дүгнэж болохоор юм.

Ангар мөрний усны нөөцөд тулгуурлан дэлхийд хамгийн томоохон Усан цахилгаан станцын байгууламжийн цогцолборыг байгуулсанд Эрхүү, Братск, Усть-Илимскийн ЦС-ууд ордог. Мөн мужийн нутаг дэвсгэрт ОХУ-даа нөөцийн хэмжээгээр нилээд дээгүүрт ордог Ковыктинскийн хийн агшаагуурын, Сухоложскийн алтны, Савины магнетитийн орд газрууд бий.

Эрхүү мужид дэлхийн цэвэр усны хамгийн том нөөц Байгал нуур оршдог нь ирээдүйд уг бүс нутгийн стратегийн хөгжилд давуу нөлөө үзүүлэх учиртай. Байгал нуурт тулгуурлан аялал жуулчлалын онцгой

* Ж.Орхон - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

бүс байгуулж, жилийн дөрвөн улирал ажиллах хүчин чадалтай онцгой бүс болгон хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулагдан хөрөнгө оруулалт зэрэг зохион байгуулалтын ажил хэдийнээ эхэлжээ.

Мужийн эдийн засгийн өсөлтийг удаашруулж буй хүчин зүйлийн нэг нь хөрөнгө оруулалтын бага урсгал юм. Үүнд нэг хүнд ногдох хөрөнгө оруулалтын хэмжээ дундаж үзүүлэлтээс даруй 1,7 дахин бага гэсэн тооцоо гарчээ. Зарим нэг тоо баримт авч үзвээс 2004, 2005 онуудад Сибирийн холбооны тойргийн хэмжээнд Эрхүү муж 7 ба 9 дүгээр байранд, харин гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээгээр 4 дүгээрт орсон ажээ. Энэхүү хөрөнгө оруулалтын хэмжээний үзүүлэлт доогуур байгаа нь үндсэн санг шинэчлэх хөрөнгийг хангаж чадахгүй байгаа ба аж үйлдвэрийн барааны чанар болон өрсөлдөх чадварын асуудлыг шийдэхэд тушаа болж эдийн засгийн өсөлтийг удаашруулах гол шалтгаан болж байна.

Эрхүү мужийн эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүд

Эдийн засгийн өсөлтийн талаар ярихаас өмнө эдгээрийг хангах бүтцийн өөрчлөлтийн тухай ярих нь зүйтэй болов уу. Энэ нь тодорхой нөхцөл болон тохирох эдийн засгийн механизмаас шалтгаалдаг. 90-ээд оноос хойш ОХУ-д тогтсон нийгэм-эдийн засгийн системд үнэлгээ хийхэд эдийн засгийн өсөлт гарах урьдчилсан нөхцөл хараахан бүрдээгүй гэсэн дүн гарч байна (зарим нэг экспортод чиглэсэн салбарыг эс тооцвол). Үүний үндсэн шинж тэмдэгт улс нийгэм-эдийн засгийн салбарыг удирдахаас аль болох зайлсхийх, аж үйлдвэрийн үр ашиг муу, нөөцийг их хэмжээгээр гадагш гаргах, үндэсний баялаг үнэгүйдэх, улс орон гадаад хүчин зүйлээс хэт хамаарах зэрэг шалтгаанууд багтана. Зарим нэг салбараар аль эсвэл хэсэгчилэн сайжруулснаар үр дүн муу байдаг, юун түрүүнд эдийн засгийн институтын бүх бүтцийг системтэйгээр эрс шинэчилж тогтвортой хөгжлийн замд гаргах нөхцлийг бүрдүүлэх шаардлагатай. Эдийн засгийн өсөлтөд нөлөөлөх хүчин зүйлд:

- Аж ахуйн ихэнхи хэсэг уг аж ахуйг хөгжүүлэх сонирхол бүхий үр ашигтай өмчлөгчийн хяналтанд орсноор өмчийн дэвшилтэт бүтэц тогтоно,

- Аж үйлдвэрийн секторт стратегийн ач холбогдол бүхий томоохон хөрөнгө оруулагчдыг татан оруулах,

- Нөөцийг үр ашигтай аж үйлдвэрийн салбарт хуваарилдаг тогтолцоог бий болгох,

- Гадаад болон дотоод зах зээлд аж үйлдвэрийн бүтээгдэхүүний төлбөрийн чадвар бүхий эрэлт хэрэгцээг хангах зэрэг орно.

Эрхүү мужийн эдийн засгийн өсөлтөд нөлөөлөх гол салбаруудад ирээдүйд хөгжих боломж бүхий дараахи салбарууд багтдаг, үүнд:

- түлш эрчим хүчний үндсэн салбарууд- газрын тос, хий, нүүрс зэрэг
- химийн болон газрын тос-химийн үйлдвэрлэл
- хар төмөрлөг
- өнгөт төмөрлөг- хөнгөн цагааны үйлдвэрлэл ба алтны олборлолт
- ой модны цогцолбор (ой мод, мод боловсруулах, целлюлоз, цаасны үйлдвэрлэл)
- аялал жуулчлалын онцгой бүс байгуулах гэх мэт.

ХАА-н салбар хэрэглэгчийн зах зээлийг бий болгоход үлэмж байр эзлэх учир мөн тэргүүлэх чиглэлд багтан оржээ. Энэ нь хөдөөг хөгжүүлэн, хөдөө тосгоны уналтыг даван туулж, өрсөлдөх чадавхийг дээшлүүлэхэд ач холбогдолтой гэж үздэг. Эдгээр салбаруудыг хөгжүүлэхийн тулд юун түрүүнд хэдэн сая, тэрбум доллараар тоологдох хөрөнгө оруулалтын томоохон төслүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай. Гэвч зарим нэг салбарын хөгжил томоохон нэг төслийн биелэлтээс бус, олон тооны дунд болон жижиг төслүүдийг хэрэгжүүлснээр илүү үр дүнд хүрэх боломжтой, тухайлбал, аялал-жуулчлал, ХАА-н, мөн алт олборлолт, мод боловсруулах, химийн зэрэг салбаруудад илүү үр ашигтай. Тэгвэл одоо салбар бүрээр авч үзье.

Түлш эрчим хүчний салбар: Газрын тосны боломжит ба олборлолтын нөөц нийт 2 тэрбум гаруй тонн байдаг бол хайгуулын нөөц нь 232 сая тонн байдгаас Дорнод Сибирийн хамгийн томоохон орд газар болох Верхнечонскийн газрын тосны орд газарт төвлөрдөг ажээ. Энэ орд газрын бэлтгэгдсэн нөөц богино хугацаанд газрын тосны олборлолтыг жилд 7-10 сая тоннд хүргэх боломж олгох боловч ашиглалтанд орох нь “Дорнод Сибирь-Номхон далай” гэх экспортын газрын тос дамжуулах хоолой барих ажлаас ихээхэн хамааралтай байна. Верхнечонскийн газрын тос дамжуулах нэгдсэн тээврийн хоолой байгуулснаар жилд 26 сая тонн тээвэрлэх боломжтой болно. Эрхүү мужийн нутаг дэвсгэрт газрын тосны дэд бүтцийг байгуулж, Верхнечонскийн орд газрын олборлолт болон аж үйлдвэрийн ашиглалтанд 4,5 тэрбум долларын хөрөнгө оруулалт шаардлагатай, мөн 10 мянган ажлын байр шинээр бий болж, бүсийн төсөвт жилд ойролцоогоор 20 сая ам.долларын орлого оруулна гэсэн тооцоо байна. Цаашид ч газрын тосны аж үйлдвэрийн олборлолт хийгээд дамжуулах хоолойг ашиглахад 4 тэрбум гаруй долларын хөрөнгө оруулалт шаардлагатай болж, 6 мянга гаруй хүн ажлын байртай болж, төсөвт нэмэлт 150 сая ам.долларын орлого орох юм. Үүнээс гадна бага оврын (40-50 мянган тонн жилд) газрын тос дамжуулах байгууламж барихаар төлөвлөсөн нь умард хэсгийн хэрэгчлэгчдийг газрын тосны бүтээгдэхүүнээр хангахад боломжтой болно.

Байгалийн хийн: нөөц нийт 8,5 трлн.куб.м бол хайгуулын нөөц нь 14%-д хүрсэн. Хамгийн их нөөцтэй газар Жигаловск дүүргийн Ковыктинскийн хийн агшаагуурын орд газар юм (С1+С2 ангилалын 2,13 трлн.куб.м нөөцтэй). Энэхүү нөөцийг 30 жилийн турш жилдээ 25-37 тэрбум куб.м хий олборлон ашиглах боломжтой ба химийн үйлдвэрийн үнэт түүхий эд болох гелий (25%), метан-этан (4,9%), пропан (1,08%), бутан (0,58%) зэргээр баялаг онцлогтой орд юм. Уг орд газрыг олборлох үе шатыг туршилтын ашиглалт (2006-2012 он), тухайн үед Эрхүү муж болон хөрш Буриад, Чита мужийг хийгээр хангах төсөл хэрэгжих үе, мөн аж үйлдвэрийн олборлолт (барагцаагаар 2013 оноос) гэж хувааж болно, энэ үед хий боловсруулах томоохон цогцолбор барьж улмаар “эрчим хүчний хий” /метаныг/ гадагш гаргахаар төлөвлөж байна. Одоогоор Эрхүү мужийг хийгээр хангах бүсийн хэмжээний 2 төсөл хэрэгжиж байна (“Дорнод-Сибирийн хийн компани” /ТНК-ВР/ болон “Газпром”-ын хэрэгжүүлж буй төслүүд).

Нүүрсний олборлолт: Эрхүү мужид 100 гаруй жил явагдаж, боломжит болон олборлолтын нөөцийн хэмжээ 46 тэрбум тонн, хайгуулын нөөц- 14,4 тэрбум тонн байна. 1960-аад оны үед нүүрсний олборлолтын оргил үе байсан бол одоо Черемховогийн сав газар болон Тулуны хар нүүрсний ордуудын нөөц шавхагдаж, 1990-ээд оноос шинээр Мугунскийн хагалбар /20 сая тонны хүчин чадалтай/ ашиглалтанд орсон байна. Олборлож байгаа нүүрсний бараг ихэнхи хувь дулааны цахилгаан станцууд, хотын уурын зуух зэрэг мужийн дотоод хэрэгцээг хангахад ашиглагдаж байгаа. Черемховогийн чулуун нүүрс чанарын хувьд муу тул (хүхэрийн агууламж өндөртэй) экспортод гаргах боломжгүй, харин чулуун нүүрсний шинэ орд газруудыг эргэлтэд оруулах нь (Вознесенск, Ишидейск гэх зэрэг) хөрш Буриад, Амур, Кемерово муж, Кемерово хязгаар нутаг, Красноярск муж зэрэг нүүрс олборлогч бусад бүсүүдийн үнийн өрсөлдөөнөөр хязгаарлагдаж байна. Иймээс нүүрсний салбарын цаашдын хөгжил түлш-эрчим хүчний балансын хэтийн бүтэцтэй зайлшгүй холбоотой. Үүнд ажиллаж буй нүүрсний цахилгаан станцуудыг хийн болгон шинэчлэх нь эдийн засгийн хувьд ашиггүй учир нүүрсний хэрэгцээг тогтвортой байлгах баталгаа болж өгнө.

Эрхүү мужийн химийн үйлдвэрийн цогцолбор 3 том аж үйлдвэрээс бүрддэг: “Ангарскийн нефтьхимийн компани” (үүнд Ангарскийн газрын тос боловсруулах үйлдвэр болон Ангарскийн полимерын үйлдвэр ордог), “Саянскхимпласт” компани (поливинилхлорид ба сод үйлдвэрлэдэг), “Усо́льехимпром” компани (сод болон карбид кальций үйлдвэрлэдэг). Эдгээр гурван компани одоогийн байдлаар томоохон аж ахуйн нэгжийн жишгээр өөрчлөлт

шинэчлэлийн шатанд оржээ. Эрхүүгийн химийн үйлдвэрүүдэд учирч буй гол хүндрэл бол газрын тосны өндөр үнэ юм, үүнээс үүдээд нефтьхимийн үйлдвэрийн түүхий эд мөн өртөг өндөртэй байна.

Өнгөт төмөрлөгийн үйлдвэр Эрхүү мужийн аж үйлдвэрийн 20%-ийг бүрдүүлдэг. Өнөөгийн байдлаар хөнгөн цагааны үйлдвэрлэл болон алт олборлолт гэсэн үндсэн хоёр салбараас бүрдэж байна. Уг салбаруудын хөгжил тодорхой нөхцөл байдлаас хамаардаг, тухайлбал хямд цахилгаан эрчим хүч, төмөр зам (БАМ, Транссиб), мөн баялаг алтны нөөц зэрэг нь илүүтэй нөлөөлсөн. Гэхдээ цаашдын хөгжил зарим нэг сөрөг хүчин зүйлээс болж удаашрах хандлагатай байна, үүнд бүсийн зам тээврийн дэд бүтцийн хөгжил хоцронгуй, үйлдвэрлэлийг өргөжүүлэхэд хямд цахилгаан эрчим хүчний хүрэлцээ муу, тээврийн тариф өндөр байгаа нь мужийн алслагдсан байдлыг улам гүнзгийрүүлж хөгжилд сөрөг нөлөө үзүүлсээр байна. Эрхүү мужийн нутаг дэвсгэрт оросын нийт хөнгөн цагааны 35% үйлдвэрлэгддэг. Үүнд “Братскийн хөнгөн цагааны үйлдвэр” болон “Эрхүүгийн хөнгөн цагааны үйлдвэрүүд” гол үүрэг гүйцэтгэдэг байна.

Эрхүү муж улсын хэмжээнд алт олборлолтын 10%-ийг бүрдүүлдэг томоохон алт олборлогч таван субъектын нэг билээ. Нөөц ихтэй үндсэн ордууд болох Бодайбийнск дүүрэг гэхэд мужийн алтны нөөцийн 95%-ийг агуулдаг, мөн Мамско-Чуйский, Нижнеудийнский, Качугский дүүргүүдэд алтны нөөц төвлөрдөг байна. Одоогийн байдлаар Сухой Лог гэх орд газрын алтны батлагдсан нөөц 1029 тонн, үүнд алтнаас гадна цагаан алтны нөөц мөн илэрсэн байна. Уг орд газрыг эргэлтэд оруулахад 4-5 жилийн хугацаанд ойролцоогоор 1,1-1,5 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай, ингэснээр жилд 3033 тонн алт олборлон бүсийн хэмжээнд алт олборлолт 3 дахин өсч 1000 ажлын байр шинээр бий болох юм. Иймд уг төслийг хэрэгжүүлснээр зөвхөн Бодайбинск дүүрэгт бус бүхэлдээ Эрхүү мужийн хөгжилд шинэ түлхэц болж, эрчим хүч, зам тээвэр зэрэг дэд бүтцийн салбарт эерэг нөлөө үзүүлэх боломжтой.

Хар төмөрлөгийн үйлдвэрлэл муу хөгжөөд зогсохгүй төмрийн хүдэр олборлож боловсруулах төдийхнөөр хөгжиж байна. Төмрийн хүдрийн нөөц шавхагдаж байгаа тул шинэ орд газар нээн ажиллуулснаар төмрийн хүдрийн нөөцийг шаардлагатай хэмжээнд хүргэнэ. Үүний тулд Красноярскийн орд газрын уурхайг барьж ашиглалтанд оруулах төслийг 2006-2015 онуудад хийхээр төлөвлөж, хөрөнгө оруулалтын хэмжээ 75 сая ам.доллар болно гэсэн тооцоо гарсан. Гэвч Оросын Дорнод хэсгийн хар төмөрлөгийн үйлдвэрийн хомсдолыг арилгахын тулд хар төмөрлөгийн салбарын хөгжлийг зөвхөн нөөц хангах хэлбэрээр бус өөрийн хар төмөрлөгийн үйлдвэр барих замаар ирээдүйн хөгжилд хөтлөх боломжтой. Үүний тулд

зөвхөн Эрхүү мужийн орд газрын нөөц түүхий эдийн суурь болоод зогсохгүй хөрш Чита мужийн хойд хэсэгт орших Чинейскийн орд газрыг ашиглах шаардлагатай юм.

Ой модны хэмжээгээр Эрхүү муж улсдаа тэргүүн байранд орж нийт нутаг дэвсгэрийн 66,8 сая га газар эзэлж, ихэнхи хувийг нарс болон навчит ой мод эзэлдэг байна. Эрхүү мужийн ой модны цогцолбор мод бэлтгэл (21,8 сая куб.м, 25,6 мянган хүн ажилладаг), мод боловсруулалт (22 мянган ажлын байр), целлюлоз-цаасны үйлдвэр (23,5 мянган хүн ажилладаг) гэсэн үндсэн салбартай. Мод боловсруулах үйл ажиллагаа явуулж буй томоохон аж ахуй болох “Илим Палп Энтерпрайз”, “Иригма-Тайрику”, “Континенталь-Менеждмент” зэрэг нь ОХУ-ын хэмжээнд нийт целлюлозын 54,7%, модон шпал 30%, мод бэлтгэлийн 15,3%, фанер 6,1%, ДСП 4,3% үйлдвэрлэдэг байна. Цаашид энэ салбарыг өргөжүүлэн хөгжүүлэхэд дараахи хөрөнгө оруулалтын төслүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай:

- 2009 он гэхэд Усть-Илимскийн целлюлозны үйлдвэрийн үйлдвэрлэлийн хэмжээг жилд 744 мянган тонн (157 мянган тонноор өснө) болгоход 83,7 сая ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай,

- Братскийн целлюлозны комбинатын шинэчлэлээр 2007-2011 онуудад 220 сая ам.долл хөрөнгө оруулалт хийгдэж, 2011онд 915 мянган тонн целлюлоз үйлдэрлэх боломжтой болно (165 мянган тонноор өснө),

- Братскийн мод боловсруулах үйлдвэр дээр тоног төхөөрөмж шинэчлэснээр фанер үйлдвэрлэх хүчин чадал 240 мянган куб.м болж өсөлт 102 мянган куб.м болно.

Эдгээр болон бусад үйлдвэрүүдийг шинэчлэхээс гадна шинээр аж ахуй байгуулах шаардлагатай байна, ингэснээр мод боловсруулах үйлдвэрлэл илүү дэвшилтэт шатанд гарч, мод боловсруулах үйлдвэрийн бүтээгдэхүүний хэмжээ болон чанарт эерэг нөлөө үзүүлэх нь дамжиггүй.

Аялал жуулчлалын салбар нь эдийн засгийн хөрөнгө оруулалтын хамгийн ашигтай салбарын нэг билээ. Эрхүү муж аялал жуулчлалын баялаг нөөцтэй, аялал жуулчлалын олон төрлийг хөгжүүлэх өргөн боломжтой, үүнд соёл урлаг-танин мэдэхүй, экологийн, спорт, эмчилгээний, загасчлах, ангийн гэх зэрэг багтдаг. Жуулчдын анхаарал сонирхолыг ихээхэн татдаг газрууд болох Листвянка, Ольхонск, Слюдянск, Качугский зэрэг дүүргүүдэд аялал жуулчлалын гол төвүүд төвлөрсөн байдаг. Эрхүү мужийн байгал-цаг уурын (Өвөр Байгалийн үндэсний парк зэрэг), түүх-соёлын (Эрхүү хот Дорнод Сибирийн түүх соёлын үнэт өв), рашаан эмчилгээний нөөц (дэлхийд хамгийн том Ангар-Ленский рашааны сав газар) зэрэг нь уг салбарын хөгжлийн гол хүчин зүйлс болдог. Гэвч энэ салбарын хөгжлийг саармагжуулж байгаа асуудал болох материал-техникийн баз нь хуучирч орчин үеийн болон олон улсын стандартад нийцэхгүй зэрэг асуудлууд байсаар байна. Эдгээрийг шийдэхийн тулд аялал жуулчлалын онцгой бүс байгуулж, зочид буудлын

цогцолборыг шинэчилж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдэх шаардлагатай. Эрхүү муж семинар болон төрөл бүрийн хурал зохион байгуулах замаар ажил хэрэгч жуулчлалыг хөгжүүлэх саналтай байгаа. Үүний зэрэгцээ усан парк, цанын базууд болон амралт зугаалгын цогцолбор барихаар төлөвлөгдсөн. Жилийн дөрвөн улиралд ажиллах амралтын газрыг Байгал нуурын эрэг дээрх Листвянка тосгоны хавьд 3000 орчим га газарт барихаар төлөвлөсөн. Барилгын нийт талбай 320 га газар эзэлж зочид буудлын цогцолбор, хурал семинар хийх 2 төв, цанын баз, усан парк, дүүжин утсан зам, мөн спорт болон амралт зугаалгын цогцолборууд баригдана. Ингэснээр нэг дор 4000 хүн гулгах боломжтой болно. Үүнд 2,18 тэрбум рубль зарцуулахаар болсон. 2026 онд эдийн засгийн онцгой бүсийн нутаг дэвсгэрт төрөл бүрийн 20 гаруй зочид буудал, хурлын 2 төв, усан парк, танин мэдэхүйн төв, худалдаа-амралтын төв, кафе, ресторан, эмнэлэг, дэлгүүр, ажилчдын орон сууц, спортын барилга байгууламж зэргийг барина. Урьдчилсан тооцоогоор, энэхүү амралтын цогцолбор нэг дор 10 000 хүн багтаах хүчин чадалтай байхаар төлөвлөгдөжээ.

Эрхүүгийн эдийн засгийн онцгой бүс байгуулах төслийг хэрэгжүүлэхэд нийт 14,64 тэрбум рублийн хөрөнгө оруулалтыг 2020 он хүртэл хийхээр болжээ. Төсвийн хөрөнгийн 1 тэрбум гаруй рублийг 3 жилийн хугацаанд эргэлтэд оруулж, энэ нь орон сууцны дэд бүтэц болон барилгын талбай байгуулахад ашиглагдахаар төлөвлөгдсөн. 1,5 тэрбум рублийг холбооны төсөв, мөн 1,5 тэрбумыг мужийн, 180-аад мянгыг орон нутгийн сангаас гаргана. Энэ хөрөнгийн ихэнхи хэсэг буюу 2 тэрбум гаруйг цахилгаан эрчим хүчний байгууламжийг барихад зарцуулна. Бусад хөрөнгийг усан хангамж болон бохирын инженерийн сүлжээ байгуулж, холбооны шугам, зам барихад ашиглахаар төлөвлөжээ. Эрхүү мужийн засаг захиргаанд өгсөн өргөдлийн дагуу “Россо Групп”, “Импекс”, “Реал Групп”, “Байгалийн Виз”, “Гранд Байгал”, “Сно-улэнд”, “Геолион”, “Оросын уулын цанын сургууль”, Үндэсний газрын гадаргуйн хамгаалалт ба хөгжлийн Үндэсний траст, мөн хятадын “Эрлинхот”, “Наньтун” зэрэг компаниуд уг төсөлд оролцохоор өргөдөл гаргасан байна.

Эрхүү мужид эдийн засгийн онцгой бүс байгуулах давуу тал олон байна: орон нутгийн эрх баригчид холбооны хөрөнгөтэй болсноор зам болон орон сууцны дэд бүтцийг барьж, хөрөнгө оруулагчид татварын хөнгөлөлт эдлэн, 20 жилийн дараа газраа хувийн өмч болгон, зочид буудал, амралтын газар мөн амралт зугаалгын төв барих боломжтой болно. Хэрэв төслийг амжилттай хэрэгжүүлбэл уг бүсэд жилд 1,3 сая хүн амрах боломжтой болно. Үүний дүнд 40 000 мянган ажлын байр шинээр бий болж аялал жуулчлалын бизнест ажилдаг хүний тоо гурав дахин нэмэгдэх төлөвтэй.

ХАА-н цогцолбор зөвхөн Эрхүү мужид бус улсын хэмжээнд хүнд байдалд байна. Энэ байдлаас гарахын тулд :

1. Том болон дунд аж ахуйд төсвийн дэмжлэг үзүүлэх шаардлагатай. Эрчим хүч болон шинэ тоног төхөөрөмж худалдан авахад төсвөөс мөнгө гаргаж эргэлтийн хөрөнгийн хомсдолоос гарахад нь дэмжлэг үзүүлэх замаар ХАА-н салбарт өсөлт гарна.

2. Худалдан авах үнийн дотаци ба хангалт, борлуулалтын дэд бүтцийн хөгжил- хөдөө аж ахуйн секторыг дэмжих энэхүү арга үйлдвэрлэгчдийг дэмжихэд чиглэсэн эдийн засгийн хувьд хамгийн ирээдүйтэй механизм юм. Мөн ХАА-н салбарыг хөгжүүлэхэд бүтээгдэхүүний борлуулалтын дэд бүтцийн хөгжил чухал хүчин зүйл болно.

3. Хөдөө аж ахуйн холдинг байгуулах нь бусад салбарын, юун түүвэнд ХАА-н түүхий эд боловсруулдаг аж ахуй, байгууллагуудын сонирхолтой холбоотой. Тэдэнд найдвартай чанартай түүхий эдийн баз хэрэгтэй учир тэд ХАА-д хөрөнгө оруулалт хийж ашиг бүхий аж ахуйг худалдан авч байна. Ингэснээр аж ахуйнууд зээл, тусламж, шинэ тоног төхөөрөмж зэргийг авч, бүтээгдэхүүн нийлүүлэх замаар төлбөрөө хийнэ.

Эрхүү мужийн стратегийн хөгжлийн зорилго ОХУ-ын бусад бүс болон экспортод бараа бүтээгдэхүүн гаргахаас гадна хөрш сибирийн бүс нутгуудтай холбоогоо өргөтгөж Дорнод Сибирийн инноваци шинж бүхий эдийн засгийг бий болгож хөрөнгө оруулалт, амьдрах таатай орчинг бүрдүүлэх зэрэгт оршино. Мужийн эдийн засаг хөгжлийн эрчимт замд шилжихэд эдийн засгийн онцгой бүс байгуулж, ОХУ-ын Ерөнхийлөгчийн тодорхойлсон үндэсний тэргүүлэх төслүүдийг хэрэгжүүлж, Эрхүү муж Усть-Ордын Буриадын автономит тойрогтой нэгдэх зэрэг нь зайлшгүй юм.

Ерөнхийдөө бүсийн эдийн засгийн хөгжил Эрхүү мужийн засаг захиргаа томоохон аж үйлдвэрийн хөрөнгө оруулалтын төслүүдийг хэрэгжүүлж, цаашид түүхийн эдийн олборлолт болон анхан шатны боловсруулалтын хэмжээг нэмж, уг бүс нутгийн ард түмний амьжиргааг дээшлүүлэх зэрэгт тулгуурлана.

Ашигласан материал:

1. Концепция социально-экономического развития Иркутской области на 2006-2010 г.г. www.vsp.ru/politic/2006/01/25
2. Социально-экономическое положение региона и условия реализации стратегии. www.irk.raexpert.ru/strategy/1/
3. Наталья Бочарова. “Делу-время: На зимний Байкал туристов будут заманивать деловыми конгрессами”. “Белый бизнес” сэтгүүд, №2 (03), 2007. Сайт - www.bb-online.ru
4. Развитие ключевых отраслей экономики объединенной Иркутской области и крупнейшие инвестиционные проекты. www.irk.raexpert.ru/strategy/3
5. Иркутская область: инновационный вектор развития. www.ideg.ru/podr/